



АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН
ТАМИР, СПОРТЫН ГАЗАРТ

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 55,
Утас: 262449, 266246 Факс: (976-11) 32 52 34
И-мэйл: info@sport.gov.mn

2025. 01. 14 № 1/24
танай _____-ны № _____-т

Тайлан хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичиг болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хавсралтаар хүргүүлж байна. Тайланд тусгасан зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллана уу.

Хавсралт ... хуудастай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



О.БАТТУЛГА

140580033

**ДОРНОД АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2025.01.13

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Дорнод аймгийн биеийн тамир, спортын газрын 2024 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үндэслэл, үнэлгээний арга зүй

Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын 4.7-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Дорнод аймгийн биеийн тамир, спортын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 51 арга хэмжээ тус бүрийн биелэлтийг жилийн эцсийн зорилтот түвшин, үр дүнтэй харьцуулан үнэлсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын явцад зарим тайлан мэдээллийн хэрэгжилтийн байдалд нэмэлт тодруулга авах, асуудал хариуцсан нэгжээс тайлбар авах зэргээр мэдээллийн чанарыг сайжруулах, бататгах ажлыг гүйцэтгэв. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ыг тус тус баримтлав.

Гурав. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.

Дорнод аймгийн биеийн тамир, спортын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийн явц 4 зорилгын хүрээнд 5 зорилт 51 арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг зохион байгуулж 43 арга хэмжээ “үр дүнтэй” буюу 100 хувь, 8 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70-99 хүртэл хувьтай тус тус үнэлэгдэж биелэлтийн дундаж 98,2 хувьтай буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна.

№	Дэс дугаар	Зорилт, арга хэмжээ	ДАБТСГ үйцэтгэлийн хувь	БТСУХ Үнэлгээ
Стратеги төлөвлөгөөний зорилго 1: Идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх /эрүүл мэндээ хамгаалах, сайжруулах/ нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй болгох.				
Зорилт-1. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэгчдийн тоог нэмэгдүүлнэ.				97%
1	1.1	Арга хэмжээ-1 Нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэгчдийн тоог нэмэгдүүлж хүн амын хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх.	100%	100%
	1.2	Арга хэмжээ-2 Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшинг тогтоох сорил авах үйл ажиллагааг зохион байгуулна.	100%	80%
	1.3	Арга хэмжээ-3: “Дорнод марафон” бүх нийтийн гүйлт арга хэмжээг зохион байгуулна.	100%	90%
	1.4	Арга хэмжээ-4: Өвлийн спортын төрлийг хөгжүүлэх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр аж ахуй нэгж, байгууллагатай хамтран ажиллана..	100%	100%
	1.5	Арга хэмжээ-5: Сумдад орон тооны нийтийн биеийн тамирын арга зүйч ажиллуулах.	100%	100%
	1.6	Арга хэмжээ-6: Үндэсний спортыг дэмжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.	100%	100%
	1.7	Арга хэмжээ-7: Багийн спортын хөгжлийг дэмжих, төсөл арга хэмжээг хэрэгжүүлнэ.	100%	100%
	1.8	Арга хэмжээ-8: Спорт заал, нийтийн болон хүүхдийн биеийн тамирын талбайг өргөтгөх, засварлах, шинэчлэх, шинээр нэмэгдүүлнэ.	100%	100%
	1.9	Арга хэмжээ: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг спортын үйл ажиллагаанд татан оролцуулна.	100%	100%
	1.10	Арга хэмжээ: Ахмадуудыг спортын үйл ажиллагаанд татан оролцуулна	100%	100%
Стратеги төлөвлөгөөний зорилго 2: Спортын сургалт дасгалжуулалт, тэмцээн наадмын шаталсан тогтолцоог хөгжүүлж, төр төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулан тамирчдын олимп, дэлхийн түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.				
Стратеги төлөвлөгөөний зорилт 2: Спортын сургалт дасгалжуулалт, тэмцээн наадмын шаталсан тогтолцоог хөгжүүлж, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулан тамирчдын олимп, дэлхийн түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.				98,3%
2	2.1	Арга хэмжээ-1: Бүс, Улс, олон улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчдад дэмжлэг үзүүлнэ.	100%	100%
	2.2	Арга хэмжээ-2: Өсвөр үеийн шигшээ багийг 3 төрлөөр байгуулна.	100%	100%
	2.3	Арга хэмжээ-3: Хүүхэд, залуусыг багийн спортоор тогтмол, тогтвортой хичээллүүлж байгаа хувийн спортын холбоо, клубийн үйл ажиллагааг дэмжиж хамтын ажиллагаа, түншлэлийг нэмэгдүүлэх.	100%	100%
	2.4	Арга хэмжээ-4: Орон нутагт шинэ тутам хөгжиж буй спортын төрлийг шинээр хөгжүүлэн дэмжиж ажиллана	100%	90%
	2.5	Арга хэмжээ-5: Аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	100%	100%
	2.6	Арга хэмжээ-6: “Хүн болох багаасаа” хүүхдийн спортын авьяасыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх	100%	100%
Стратеги төлөвлөгөөний зорилго 3: Олон улс, улсын аварга, бүсийн тэмцээнүүдийг зохион байгуулах				
Стратеги төлөвлөгөөний зорилт 3: Олон улс, улсын аварга, бүсийн тэмцээнүүдийг зохион байгуулах				99,2%

3	3.1	Идэрчүүдийн улсын аварга шалгаруулах Волейболын тэмцээн	100%	100%
	3.2	Ахмадын улсын аварга шалгаруулах ширээний теннисний тэмцээн	100%	100%
	3.3	Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах шатарын тэмцээн	100%	100%
	3.4	Үндэсний сурын улсын аварга шалгаруулах тэмцээн	100%	100%
	3.5	Хөнгөн атлетикийн улсын аварга шалгаруулах тэмцээн	100%	100%
	3.6	Политехник коллежийн 100 жилийн ойн хүрээнд улсын аварга шалгаруулах тэмцээн	100%	100%
	3.7	Зүүн бүсийн Волейболын өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн	100%	100%
	3.8	Зүүн бүсийн аварга шалгаруулах жүдо бөхийн тэмцээн	100%	100%
	3.9	Сумын заан цолтой залуучуудын зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээн	100%	100%
	3.10	Үндэсний сурын зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээн	100%	100%
	3.11	Сагсан бөмбөгийн өсвөр үеийн зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээн	100%	90%
	3.12	Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 7 аймгийн Зүүн бүсийн аварга шалгаруулах спортын олон төрөлт тэмцээн	100%	100%
	3.13	Дорнод аймгийн цагдаагийн газрын Зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээн	100%	100%
Стратеги төлөвлөгөөний зорилго 4: Төрийн байгууллагын нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ				
Стратеги төлөвлөгөөний зорилт:4 Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Биеийн тамир, спортын тухай хууль болон бусад холбогдох хууль, төрөөс биеийн тамир, спортын талаарх баримталж буй бодлого шийдвэрийн хангаж мөрдөх				100%
4	4.1	Арга хэмжээ-1: Ажилтан албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна.	100%	100%
	4.2	Арга хэмжээ-2: Өмч ашиглалтын бүртгэл мэдээллийн санг үүсгэн элэгдлийг тооцож, шинэчлэл хийнэ.	100%	100%
	4.3	Арга хэмжээ-3: ХАСХОМ мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлж авилга ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг байгууллагын түвшинд зохион байгуулна.	100%	100%
	4.4	Арга хэмжээ-4: Иргэн аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэнэ.	100%	100%
	4.5	Арга хэмжээ 5: Хэвлэл мэдээллийн болон олон нийтийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, салбарын үйл ажиллагааг сурталчилна.	100%	100%
Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ний биелэлт				97,6%
	1	"Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	100%	100%
	2	Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх журмын дагуу улсын бодлогын баримт бичгүүдээс салбарын хүрээнд хамааралтай заалтуудыг бүрэн хяналтад авч хэрэгжилтийг хангаж ажиллах	100%	100%
	3	Байгууллагын хэмжээнд цахим шилжилтийг эрчимжүүлэх, Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, түүнд тавих хяналтыг сайжруулан "Эйбл" программын ашиглалтыг нэмэгдүүлж албан хаагчдын бүтээмжийг нэмэгдүүлэх, дэвшилтэт технологи, арга хэлбэрийг нэвтрүүлэн ажиллах	100%	100%
	4	Байгууллагын эцэг эхийн зөвлөл ажиллах, Хүүхдийн эрсдэлийн үнэлгээ,	100%	100%
	5	Цахим үндэстэн болох арга хэмжээг эрчимжүүлж нийтийн мэдээллийг боловсронгуй болгож цаашид цахим харилцаанд шилжиж нийтийн мэдээллийн системээс олж авах, солилцох боломжтой тул иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх	100%	100%
	6	Иргэн, ААН, байгууллагуудаас Төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэнэ.	100%	100%

5	7	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах	100%	100%
	8	Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах	100%	100%
	9	Төрийн сангийн төлбөр тооцоо, портал системээр хийгдэж цахим хэлбэрт шилжсэнтэй холбоотойгоор сумдын санхүүгийн алба, орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүгийн ажилтнуудыг цахим орчинд ажиллах нөхцөл, бололцоогоор хангаж ажиллах	100%	100%
	10	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж, ашиглалтад хүлээн авсан барилга, байгууламж, тоног төхөөрөмж, бараа материалыг зориулалтын дагуу ашиглаж байгаад хяналт тавих, орон нутгийн өмчид бүртгэлжүүлэн ашиглалт, хамгаалалтыг бүрэн хариуцна.	100%	90%
	11	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах, сул орон тооны зарыг тухай бүрд нь мэдээлж, хүний нөөцийн бүрдүүлэлтийг хангаж ажиллах	100%	100%
	12	Төрийн албан хаагчийн сургалт, хөгжил, нийгмийн баталгааг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж, албан хаагчдын нийгмийн баталгааг хариуцлагатай дэмжигч төрийн байгууллага болзолт уралдааны биелэлтийг хангах	100%	90%
	13	Архидан согтуурахтай тэмцэх, ажлын байранд архидан согтуурсан, согтуугаар жолоо барьсан төрийн албан хаагчдад хариуцлага тооцох, соён гэгээрүүлэх нөлөөллийн ажлыг оновчтой зохион байгуулах	100%	90%
	14	Аймгийн Зорилтот жилийн хэрэгжилтийг хангаж ажиллах	100%	100%
	15	Аймгийн ЗД-ын 2024 оны захирамж, албан даалгаврыг хяналтад авч хэрэгжилтийг тайлагнаж ажиллах	100%	100%
	16	Дорнод аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2024 оны зорилтын хэрэгжилтийг хангаж ажиллах	100%	100%
	17	Аймгийн ЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2024 оны зорилтын хэрэгжилтийг хангаж ажиллах	100%	90%
Биелэлтийн дундаж хувь				98,2%

Дөрөв. Дүгнэлт

Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлт, биелэлтэд үнэлгээ өгөх, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, шийдвэр нь үр дүнтэй байсан эсэх, гарсан алдаа, дутагдлыг арилгах, дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд чиглэдэг билээ. Дорнод аймгийн биеийн тамир, спортын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтийн дундаж **98,2** хувьтай буюу “тодорхой үр дүнд хүрсэн” байна. Төлөвлөгөөнд туссан зарим арга хэмжээний биелэлт, тайлагналт хангалтгүй байна. Тухайлбал хэрэгжүүлсэн арга хэмжээний тушаал, шийдвэр, удирдамжийн дугаар, огноо байхгүй байна. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 5 зорилт бүхий 51 арга хэмжээнээс 43 арга хэмжээ нь 100 хувь буюу “үр дүнтэй” хэрэгжсэн байна.

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан “Аргачлал, загвар батлах тухай” тушаалыг мөрдөж ажиллаагүй ноцтой зөрчил гаргасан байна. Мөн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг оновчтой тодорхойлоогүй, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшинг холбогдох журам, аргачлалын дагуу тодорхой, хэмжигдэхүйц байдлаар томьёолоогүй зөрчил дутагдал байна.

Тав. Зөвлөмж: Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ.

Бүх албан хаагчдад:

1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнахдаа, хүрсэн үр дүнг зарцуулсан төсөвтэй уялдуулан нотлох баримттай тайлагнах, зөвлөмжийн биелэлтийг ханган ажиллах,

2. Тухайн төлөвлөсөн арга хэмжээ хэрэгжихгүй байх эрсдэлийг урьдчилан тооцоолох, хариу арга хэмжээг шуурхай авч ажиллах, хэрэгжээгүй тохиолдолд шалтгаан нөхцлийг тодорхой тайлагнаж байх,

Удирдлагуудад:

1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хэрэгжилт хангалтгүй үнэлэгдсэн арга хэмжээг 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нэмэлтээр тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллах,

2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнахдаа төлөвлөлтийг оновчтой тодорхойлох, тухайн жилийн зорилт, арга хэмжээ, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, суурь түшинг тооцоо судалгаанд үндэслэн бодитой тодорхой тусгасан шаардлага хангасан тайланг нэгтгэх мөн Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэгт заасан зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг тус тус зөвлөмж хүргүүлж байна.

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, “Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан “Аргачлал, загвар батлах тухай” тушаалыг тус тус мөрдөж, төлөвлөлтийг сайжруулахад анхааран ажиллана уу. Та бүхэнд амжилт хүсье.

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



О.БАТТУЛГА

ХЯНАСАН:

ХШУДАХ-ИЙН ДАРГА

A handwritten signature in black ink, likely belonging to N. Batcux, is written over the bottom part of the red stamp.

Н.БАТСҮХ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХШУДАХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН *Б. Уранбилэг* Д.УРАНБИЛИГ